

ИХ МОНГОЛЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ ДАХЬ ХОЛБООНЫ УЛСЫН ХЭВ ШИНЖ, ТҮҮНИЙ УЛС ТӨРИЙН ЗАСАГЛАЛ НЬ ПАТРИМОНИАЛЬ БЮРОКРАТ ТОГТОЛЦООТОЙ БАЙСАН НЬ

Ц.Батболд

Монгол Улсын Их Сургуулийн Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Улс төр судлалын тэнхим

Өгүүллийн товч утга: Их Монголын төр, засаглалын төвлөрлийг дотооддоо бие даасан хаант улсууд буюу автономит засаглалын аргаар шийдвэрлэж, их хааны төв засаглалыг төрийн патримониаль бюрократуудын хүчээр явуулж байсан. Их Монголын төрийн байгуулал нь холбооны улсын шинж чанартай байжээ.

Түлхүүр үг: шинэ элитүүд бүрдэх циркуляци, холбооны улсын шинж чанар, патримониаль бюрократ

Нэг. Их Монголын гүрний төрийн байгуулал дахь холбооны улсын хэв шинж

XII зууны сүүлч XIII зууны эхээр Монгол оронд олон жил үргэлжилсэн бутрал тэмцлийг зогсоож нэгдсэн төр улсыг байгуулахаар Тэмүжин тэргүүтэй Хамаг Монгол аймаг хатуу ширүүн тэмцлээр шалгаран гарч ирсэн билээ. Ийнхүү нүүдэлчид 1206 онд нэгдсэн төр, улсаа байгуулж, Тэмүжинг Чингис хаанаар өргөмжилсөн билээ. XIII зууны үеийн Монголын улс төрийн систем нь Их хурилдай бүхий хаант засаглал дээр тогтож, “хамгийн гол нь хэн бугай ч Их хурилдайг алгасан хааны титэм хүртэх хууль зүйн болон ёс суртахууны эрхгүй”¹ төрийн механизмийг бий болгосон явдал нь түүний онцлог юм”.

Төрийн тэргүүн хаан нь улс орны тулгамдсан асуудлаар язгууртны хурилдай, Сэцдийн зөвлөлгөөнөөр төрийн бодлогоо нягтлан үзэж шийдвэр гаргадаг байсан юм. Чингис хааны төрийн бүтэц, зохион байгуулалт нь шат дамжлага цөөхөн, эрхлэх ажлын хуваарь нь тодорхой, чанд дэг журам, сахилгыг эрхэмлэдэг, төрийн үйл ажиллагааны бүх шатанд итгэх, итгүүлэх аргыг гол болгодог, үнэнч шударга зүтгэлийг үнэлдэг, шудрага ёсыг үйл ажиллагааныхаа гол шугам болгон ихэс дээдэс, эзэн хаандаа үйлчилдэг, цомхон хэлбэртэй байжээ. Тухайн үеийн төрийн мөн чанарт Чингис хааны үзэж байснаар “эзэн ноён бол төрийн нэг хэсэг, хаан бол төрийн тэргүүн, хаан болон эзэн ноёндoo зүтгэнэ гэдэг бол төрдөө зүтгэж буй явдал мөн. Хаан болон эзэндээ тэрсэлсэн хүн бол төрийн эсрэг тэрсэлсэн гэж үзэж, түүнийг алах

¹ Ж.Бсдбаатар Ц.Батбаяр З.Баасанжав, Монгол улсын түүх, УБ., 1999, х 76.

ёстой. Харь дайсан ч байсан эзэндээ үнэнч байна гэдэг бол төрдөө үнэнч байна гэсэн үг. Эзнээсээ урвасан боол төрөөсөө урвасантай адил учраас ийм хүнд итгэж болохгүй. Ийм хүнийг устгах нь төрийг цэвэрлэж, тогтвортой болгож буй хэлбэр гэж үзэж байв. Иймээс тухайн үеийн монголчуудын төрөө дээдлэх сэтгэлгээ нь эзэндээ үнэнч зүтгэх сэтгэлгээтэй холбоотой байсан юм”¹ гэж ойлгож болно. Монгол нутагт үргэлжилж байсан олон жилийн хямралт байдал эцэс болж, шинэ элитүүд бүрдэх циркуляци явагдсан нь нийгмийн динамикийн эрчийг нэмэгдүүлсэн юм.

Монгол улсын төрийн тогтолцоо нь Эзэн хаан, Их хурилдай, хааны дэргэдэх Сэцдийн зөвлөл, Шүүх, Хишигтэн, Улсын ван буюу ерөнхий сайд, мөн Хүннүгийн үеэс уламжлагдаж ирсэн, баруун, зүүн, төвийн түмэн, мянгат, зуут, аравт хэмээх цэрэг, засаг захиргааны аравтын системтэй байв. Цэрэг, засаг захиргааны аравтын тогтолцоо нь хүн амын тоо, эдийн засгийн нөөц, бололцоо, цэрэг зэвсгийн хүчин чадал зэрэг олон хүчин зүйлийг тооцоолон, улс орны хүчийг зангидсан гар мэт төвлөрүүлэн чиглүүлэхэд онцгой ач холбогдолтой ажээ. Монголын нүүдэлчин ард түмний төрийг удирдан жолоодож, харийн халдлагаас хамгаалахад, үүнээс өөр зохимжтой зохион байгуулалтын боломж тэр үед байгаагүй юм. Тухайн үед шинээр байгуулагдсан залуу Монгол улсыг гадаад дотоодын олон орон дайсагнан хүлээн зөвшөөрөхгүй байсан явдал нь Чингис хааныг улс орноо оршин тогтноулахын тулд дайтахаас өөр аргагүй байдалд хүргэсэн билээ.

Судлаачдын бүтээлээс үзэхэд: Чингис хааны үеэс уламжилж ирсэн “Морин дэл дээр ертөнцийн талыг эзлэх амархан, харин мориноосоо буугаад төрийг төвхнүүлэх гэдэг хэцүү билээ” гэсэн үгний учрыг Чу мэргэн буюу Елюй Чуцайн хэлсэн нь “Морин дэл дээр байгуулсан төрийг, бийр янтайгаар удирдахаас өөр арга үгүй” гэжээ. Энэ үед худам монгол буюу уйгаржин бичгийг төрийн бичиг болгож, бичиг үсэг сургах ажлыг өргөжүүлэн, төрийн захидал бичгийг тамга тэмдэгээр баталгаажуулах болсон байна. Монгол улс өргөжин бэхжихийн хэрээр нийгмийн харилцааны нарийн төвөгтэй байдлыг зохицуулсан бичигдмэл “Их Засаг” хууль гарчээ. Энэ хууль нь нийгмийн олон талын харилцааг агуулсан нилээд төгс төгөлдөр хууль байсан бөгөөд энэ хууль эзэнт гүрний өнцөг булан бүрд хэрэгжиж байсан нь дэлхий дахины эрх зүйн хөгжилд том нөлөө үзүүлжээ. Америкийн эрдэмтэн Ж.Вернадский: “Их Засаг” бол хэв хуулийн

¹ Ц.Батболд, Монголд тулгар төр тогтох үе дэх улс төрийн засаглалын патримониаль маягийн хэв шинжийн онцлог, Түүх IV, Эрдэм шинжилгээний бичиг, № 245 (24), МУИС, НШУС, УБ., 2005, х 64.

үндсэн дээр шинэ тутам тогтсон төрийн засаг захиргаа, цэрэг, эрүү шүүлт, худалдаа, хэв заншил тэргүүтэн, олон төрөл зүйлийг багтаасан бүрэн төгөлдөр их хууль гэж тодорхойлжээ¹.

Монголчуудын байлдан тохинуулалт буюу “эцсийн далай хүртэлх газар, оронд энхийг тогтоон журамлах нь”² Монгол улсыг олон үндэс угсааны их гүрэн болгосон учраас, тэдгээр олон үндэстэнүүдийг нэгдсэн удирдлагаар хангахын тулд, засаг захиргааны зохион байгуулалтыг өөрчлөх, хууль дүрэм журмыг боловсруулах асуудал, шаардлага зайлшгүй хэмжээнд тавигдсан юм. Чингис хааны тухайн нөхцөл байдлыг зохицуулан, төрийг төвхнүүлэх бодлого нь дөрвөн хан хүүгийн мэдэлд хуваарилагдсан, тодорхой хэмжээний бие даасан хаант улсууд бүхий Их хаан болон Их хурилдайд захирагдсан холбооны шинжтэй гүрэн улсын үндсийг тавих, түүнд үйлчлэх хуулийг боловсруулах явдал байсан юм. Тийм ч учраас Чингис хаан Чанчунь бомбо болон бусад мэргэдийн үгийг сонсох нь тэдгээр үндэстнүүдийн эрх зүйд үл харшлах нийтлэг хууль ёсыг тогтоохыг хичээж байсантай холбоотой билээ. Гэвч бүх зүйлийг тооцох аргагүй, мөн тухайн цаг үеийн хууль, эрх зүйн түвшин сул буюу бараг бий болоогүй, зөвхөн шашин суртлын баримжаалалтай байсан тул, “Их Засаг” хуулинд ямарваа хүн алив шашин суртлыг шүтэх нь чөлөөтэй хэмээн тунхаглаж, төр төвийг сахин, аль нэг шашныг онцлохгүй байхыг заасан юм. Үүний үр дүнд олон үндэстэн, угсаатнаас бүрдсэн, олон төрлийн шашинтай, асар их газар нутаг, хүн ам бүхий их гүрний төрийг тогтоон барьж удирдах асуудал нь шинэ бүтэц, зохион байгуулалтыг бий болгох шаардлагатай тулгарсан юм. Чингис хаан болон түүний залгамжлагчид төрийн төвийг сахих байр суурийг бэхжүүлж, тухайн орон нутгууд дахь автономи хэлбэрт хаант улсууд нь дотоод асуудлаа бие даан шийдвэрлэх бололцоог олгосон бүтэц зохион байгуулалтыг анх удаа хэрэгжүүлснээр Их Монголын төрийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

XIII зуунд Монгол улсыг “Их Монгол” хэмээн нэрлэх болсон учир шалтгааны үндсийг түүний төрийн бүтэц, зохион байгуулалттай нь холбож үзвэл, Өгөдэй хааны үеэс эхлүүлэн ойлгож болох юм. “Монголын Нууц Товчоо”-нд дурьдсанаар “Хулгана жил (1229) Цагадай, Бат тэргүүнтэн баруун гарыг эзэлсэн хөвгүүд, Отчигин ноён, Жэу,

¹ Ж.Болдбаатар Ц.Батбаяр З.Баасанжав, Монгол улсын түүх, УБ., 1999.

² Д.Чулуунжав, Монголын байлдан дагууллын шалтгаан, нөхцөл, үр дагаварын асуудалд, /Философи эрхийн судлал, боть 20, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Философи Социологи Эрхийн Хүрээлэн/ УБ., 2006, х 219.

Есүнхэй тэргүүнтэн зүүн гарыг эзэлсэн хөвүүд, Толуй тэргүүнтэн голыг эзэлсэн хөвүүд охид, түмний ноёд, мянганы ноёд бүгдээр Хэрлэний Хөдөө аралд (Хуралдай) хурж, Чингис хааны гэрээсэлсэн зарлигийн ёсоор Өгөдэйг хаан өргөмжлөв”¹ гэжээ. XIII-XIV зууны Монголын түүхийн асуудлыг орчин үеийн судлаачдын бүтээлүүдээс гадна, эртний сурвалж бичиг, тухайн үеийн нийгмийн сэтгэлгээ түүний уг сурвалж болох ардын аман зохиол, үг хэллэг, археологийн олдвор, түүх соёлын дурсгал, мөн гадаад улс орнуудын түүхтэй холбон, логик дэс дараалалтай авч үзэх нь бодит байдалд илүү нийцэх буй заа. Сурвалж бичгийг тухайн цаг үеийн нь улс төр, шашин, үлгэр домгийн үнэлэмжээс нь салгах болон холбох байдлаар тодруулан энэ өгүүлэлд авч үзсэн юм. Энэ талаар “XIII зууны үед Монголд ирсэн Плано Карпини, Вильгелм Рубрук, Марко Поло нарын үзэж, сонссон гэрч баримт онцгой ач холбогдолтой”² гэж БНМАУ-ын түүхийн нэмж засварласан гурав дахь хэвлэлд тэмдэглэсэн байдаг.

Энэ үүднээс дээрх ишлэлд “Их хаан” гэсэн нэр томъёо дурьдагдаагүй нь холбооны шинжтэй их улсын, эрх зүйн чадамж бүрдэж амжаагүй байсныг харуулж буй юм. Гэвч нэн удалгүй Далай хаан буюу Их хаан хэмээн бусад хаадаас ялган нэрлэх болсон байна. Чингис хаан морин дэл дээр байгуулсан улсаа 4 хүүдээ хувааж өгсөнөөр, тэдгээр улсууд нь Их Хаанд захирагдсан, дотоод хэргээ бие даан шийдвэрлэх эрх бүхий нэгэн том улсуудын бүлэг болсон юм. Их Монгол улсын төрийн гадаад хэргийн асуудлыг зөвхөн Их хаан ба түүний төрийн аппарат хэрэгжүүлж байсныг П.Карпини, Г.Рубрук нарын аялал Бат, Сартах нарын өргөөгөөр дамжин Хархүрэм хүрсэн явдлаар илэрдэг. Жишээ нь “Бат хаан өөрийгөө, Францын ван IX Людовикаас Рубрукт даалгасан монголчуудын дунд загалмайт шашныг сурталдах хэргийг дангаар шийдэж соёрхох эрхгүй хэмээн үзсэн”³ байна. Мөн Өгөдэй хаан Их Монгол улсын чанартай томоохон шинэчлэлийн шийдвэрээ, бусад хаадтай зөвлөлдөн гаргаж байжээ. Тухайлбал, тэдгээр хаадын зүгээс “бүгдийн хооронд өртөө зам тавья гэдэг зөвөөс зөв үгийг дуртгажээ”, ...”би эндээс угтуулан өртөө зам байгуулж холботугай”⁴ гэж хариу илгээж байв. Нөгөө талаар бага хаант улсуудын зүгээс гадаад улс орнуудтай хийх томоохон дайн байлдааны асуудлыг Их хаанд мэдэгдэн, Их хурилдайгаар гүрний хэмжээнд хэлэлцүүлэн дэмжлэг авдаг байв.

¹ Монголын нууц товчоо, Ц.Дамдинсүрэнгийн орчуулга, УБ., 1947, 1976, 1990.

² Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх, УБ., 1981, х 25.

³ Гильом де Рубрук, Дорно этгээдэд зорчсон минь, /Оршил Ү.Нямдорж/ УБ., 1988, х 97.

⁴ Монголын нууц товчоо, Ц.Дамдинсүрэнгийн орчуулга, УБ., 1990, х 252.

Жишээ нь 1235 онд хуралдсан Их хурилдайгаар Бат хааны хүсэлтийг авч хэлэлцэн, Цагадайн саналаар бүх гүрэн даяар ахмад хөвүүдийг Орос, Европ руу дайнд мордуулсан юм.

Ази, Европыг дамнасан Их гүрнийг удирдан, олон жилээр оршин тогтноулах явдал нь нэгэн хааны өргөөнөөс шийдвэрлэгдэх асуудал биш юм. Германы нэрт социологич Макс Вебер “Дорно дахинд захиргааны ажлын амжилтыг хариуцах хувийн хариуцлагаас Султаныг бололцооны хирээр чөлөөлөх хэрэгцээ нь ‘Их Сибирийн’ хэвшмэл дүрийг бүтээжээ”¹ гэсэн байдаг нь Монголын их гүрний патримониаль бюрократын “ideal type” бүтцийн тухай хэлсэн хэрэг юм. Мөн судлаач Д.Чулуунжав “Их Монгол улс оршин тогтнож ирсэн 54 жилийнхээ 20 хувьд нь буюу нийтдээ 10 жилийн туршид Их хаангүй байсан явдал юм. Их хааныг товлон сонгож завдахгүйгээр өнгөрөөсөн эл 10 жилийн дотор улс орон эвдэрч, төр самуурч, дотооддоо хямарч болох байсан хэдий ч тийм талын сөрөг үзэгдэл бараг байхгүйгээр харьцангуй тайван өнгөрөөжээ. 10 жилийг хаангүйгээр байж чадсан нь тухайн цагийн Монголын төрийн байгуулал хэр их бат бэх, хэр сайн зохион байгуулалттай, хэр их амьдрах чадвартай, хэр их хүчтэй уламжлал, энерги бүхий байсныг харуулах нэгэн шалгуур мөн болно”² гэж бичжээ. Эдгээр нь Их Монголын төрийн патримониаль бюрократ аппаратын тухай дурьдсан хэрэг гэж үзэж байна. Эдгээр үйл явдлууд нь Их Монголын төр, төвлөрлийг дотооддоо бие даасан хаант улсууд буюу автономит засаглалын аргаар шийдвэрлэж, их хааны төв засаглалыг төрийн патримониаль бюрократуудын хүчээр явуулж байсныг харуулж байгаа юм. Хэрэв Их Монгол гүрний төрийн бүтэц зохион байгуулалт нь ийм бус байсан бол, 10 жил битгий хэл, 10 өдөр ч оршин тогтнож чадах логик үндэсгүй төдийгүй, патриархаль буюу уламжлалт язгууртны хаангүй төр, нэг өдөр ч оршин тогтнож чадахгүйг түүх гэрчилдэг. Монголчууд эрт үеэс гүрэн хэмээх нэр томъёог олон улс үндэстнүүдийг нэгтгэсэн хаант улс гэж ойлгож иржээ. Энэ ч утгаараа тэр үеийн үг хэллэг болох “Могой гурав тасравч гүрвэл хэвээрээ, Монгол гурав хуваагдавч гүрэн хэвээрээ” гэдэг хэллэг уламжлагдсан ажээ. Үүнээс үзвэл Их Монголын төрийн байгуулал, бүтэц зохион байгуулалт нь холбооны улсын шинж чанартай байжээ.

¹ Макс Вебер, Улс төр бол мэргэшил мөн, Шинжлэх ухаан бол мэргэшил мөн, /Ү.Нямдоржийн орчуулга/ УБ., 2000, х 25.

² Д.Чулуунжав, Монголын байлдан дагууллын шалтгаан, нөхцөл, үр дагаварын асуудалд, /Философи эрхийн судлал, боть 20, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Философи Социологи Эрхийн Хүрээлэн/ УБ., 2006, х 216.

Хоёр. Их Монголын гүрний улс төрийн засаглал дахь патримониаль бюрократ тогтолцоо

Эртний Египед болон Грек, Ром, Византид бюрократ удирдлагын анхны хэлбэрүүд оршиж байсан. Мөн эртний дорно дахины Энэтхэг, Хятад зэрэг нилээд улсуудад төрийн бюрократ элементүүд тодорхой хэмжээнд хөгжиж байсан юм. Азийн эзэнт гүрнүүдэд Европоос өмнө патримониаль бюрократ ёс уламжлагдаж ирсэн бөгөөд шинжлэх ухаанд “Дорно дахины диспотизм” гэдэг нэр томъёогоор өөрийн тодорхой бюрократ загвараар хүлээн зөвшөөрөгджээ. М.Вебер өөрийн патримониализмын судалгаандаа төрийн засаглалын үндсэн гурван хэлбэрийг тодруулсан юм. Патримониализмын тухай үгийн өөрийн утга агуулгаар нь авч үзэхэд уламжлал давамгайлсан засаглалын тухай ярьдаг. Хэрэв эзэн хаан цэргийн хүчинд тулгуурлан өөрийн бодлоор уламжлалыг үгүйсгэж үйл ажиллагаагаа явуулдаг бол ийм дэглэмийг “султанизм”¹ гэдэг нэр томъёогоор тэмдэглэж байв. Үүний зэрэгцээ М.Вебер патримониализмын төвлөрлөлгүй хувилбар болох “язгуурын” засаглалын тухай авч үзсэн. Патримониализмын энэ төрөлд эзэн хааны ноёрхол нь уламжлалт ёсоор бус, харин түүний түшмэлүүдийн эрх мэдэл ба эрх ямбаар хязгаарлагдмал байсаар тодорхойлогддог. Дээр дурьдагдсан патримониаль засаглалын хэлбэрүүдийг “цэвэр төрлүүд” (ideal-type) гэж үзэх нь зүйтэй². Европын абслют монархи гарч ирсэнээс хойш засгийн газрын аппарат аажмаар томорч эхэлсэн. Тюдорсийн үеэс эхлэн улсын удирдагч монополи эрхтэй байсан бол феодал систем түүнээс ялгаатай байв. Зөвхөн хаан л хуулийн хүрээнд биеийн албадлага эрхлэх эрхтэй байв. Хааны эрхийг түшмэдүүд гүйцэтгэдэг байв.

М.Вебер “патримониализмын ялгагдах онцлог үндсэн шинж нь эзэн хааны гарт тусгай удирдлагын аппарат үйлчилж байдаг явдал бөгөөд энэ нь патриархаль засаглалын бүтцэд байдаггүй зүйл юм. Хэрвээ патриархаль засаглал нь өв уламжлалыг даган мөрдөж байдаг бол, патримониализмд гол тулгуур нь (эзэн хааны хувийн мэдэлд байдаг түүний зэвсэг болж байдаг) удирдлагын аппарат ба цэргийн хүчин болж байдаг байна”³. Дорно дахины бюрократ загварын гол зарчим нь тухайн гүрэн, улсын эзэн хааныг болон түүний төрийг дээдлэх явдал бөгөөд түшмэлүүд нь

¹ Weber M. мөн тэнд. S.133.

² М.В.Масловский. Теория бюрократии Макса Вебера и современная политическая социология /Полис/. М., 1997.

³ Weber M. Wirtschaft und Gesellschaft. Tübingen, 1976. S.133, 134.

эзэн хаанаар толгойлуулсан их гэр бүл буюу төрийн өмчийг эрхлэгчид төдий юм. Дорно дахинд хүний мөн чанарыг арга, билиг буюу гэрэл ба харанхуй өөрөөр хэлбэл сайн, муу хоёрын харшил гэж үздэг байсан бөгөөд үүнээс үүдэн бюрократын зорилго нь нийгмийн сонирхолд үйлчлэх бус харин тэнгэр заяат эзэн хаан буюу төрийн засаглалын нөхцлийг хангаж хэрэгжүүлэх төдийгүй, үүний тулд хүмүүсийн сайн, муу үйлдлийн сөрөг үр дагаварын нөлөөллийг зөөлрүүлэх үүрэгтэй байжээ. Мөн түшмэлүүдийг албан тушаалд шалгаруулах шалгалтын систем нь зөвхөн эзэн хаан болон төрд үр ашигтай үйлчлэх чадварыг л шалгаж авч байсан нь түүхэн нөхцөл байдалд системийг тогтвортой өөрчлөлтгүй байх нөхцлийг хангаж байсан юм.

Дорно дахины бюрократизмыг ихэвчлэн хятадын бюрократ загвараар төлөөлүүлэн авч үзэх хандлага Европт давамгайлдаг байна. Эртний хятадын гүн ухаантан Күнз "засгийн албыг хаахын өмнө тодорхой улс төрийн мэдлэгээр шалгалт өгөх ёстой" гэж үзэн, төрийн түшмэдийн талаар "Баримт бичгийн судар" хэмээх бүхэл бүтэн сургаал боловсруулсан байдаг. Бараг XX зуун хүртэл 2000 шахам жил оршин тогтносон хятадын түшмэдийн систем нь тогтвортой байсны цорын ганц нууц нь түшмэд өөрийгөө бие даасан улс төрийн хүчин гэж ойлгох нөхцөлгүй байсан ба эзэн хааны патримониаль зарц хэвээр байсанд оршино. Азийн бусад орны деспотизмийн бюрократ зохион байгуулалт нь хятадынхаас доогуур түвшинд байсан бөгөөд тийм ч учраас тэд түүхэндээ тогтвор султай хөгжиж ирсэн байна. Үүний ялгаатай тал нь ард түмнээс хураан авч буй татварын нэг хэсгийг түшмэл өөртөө завшдаг байдлыг Монголчууд Юань гүрний үед ёс төдий ч хяналтын механизмтай болгосон явдал юм. Тухайлбал, Их хааны харьяат газар орны ард түмнүүдээс хураан авч буй орон нутгийн татварын нэг хэсгийг, түшмэл өөртөө завшдаг байсан бөгөөд учир нь хааны сангаас тэдэнд цалин олгодоггүй байсан юм. Учир нь яамдын түшмэд болон өндөр албан тушаалтай засаг захиргааны түшмэлүүдэд цалин олгож байснаас бус бусдад нь олгох боломж, нөхцөл ч байгаагүй юм. Тиймээс төрийн сангаас тогтоосон татварыг өгч чадаж байвал, тэдгээр түшмэдийг огт хянадаггүй байв. Гэвч зарим газар орноос Их хааны санд тогтоосон татварыг төлж чадахгүйд хүрсэн тохиолдолд хяналтын комисс томилон шалтгааныг тогтоож¹ (Марко Поло өөрөө ч хяналтын комиссын гишүүнээр удаа дараа томилогдож байжээ) тайлганадаг байв. Хэрэв байгалийн ган, зуд зэрэг шалтгаан байвал, хааны шийдвэрээр тодорхой хугацаагаар татварыг

¹ Марко Поло. Орчлонгийн элдэв сонин, УБ., 1987.

бууруулах буюу чөлөөлдөг аж. Харин тийм бус бол, тухайн газар орныг захирагч түшмэлүүд татварыг их хэмжээгээр завшсан, эсэхийг хянан тогтоож огцруулах мэтээр арга хэмжээ авдаг байв. Энэ нь түшмэлүүдийг хаан болон түүний засгаас хараат болгож, өөрийн завшсаныг бусдаас нуух үүднээс засгийн эсрэг корпоратив бүлэглэл үүсэхгүй байх боломжийг бүрдүүлж байсан. Өөрөөр хэлбэл, түшмэл нь албан тушаалаа өмчилж, татвар завшин амьдардаг бөгөөд энэ шалтгааны улмаас байнгын айдастай байдаг тул, бие даасан хүчин болох, боломжгүй төдийгүй, иерархи шатлалын хараат байжээ. Ийм хяналтын систем нь их гүрний засаглалыг бат, бэх болгож байжээ.

Азийн ихэнх орнуудад үүнийг орхигдуулсан байсан нь Хубилай хааны үед Их Монгол гүрэн задарч, гадаад, дотоод бүх асуудлаа өөрсдөө шийдвэрлэх эрх бүхий тусгаар улс, гүрнүүд болсонтой нэг талаар холбоотой юм. Тухайлбал Энэтхэгт түшмэдүүдийн өөртөө завшдаг байдалд зайлшгүй байх ёстой мэт философийн үүднээс тэсвэртэй ханддаг байсан. Бүүр 2500 жилийн өмнө эзэн хаан Чандрапурта Маурягийн ерөнхий сайд Каутилья өөрийн бичсэн “Арташастра” гэдэг номондоо түшмэлүүд төрийн орлогоос 40 төрлөөр өөртөө завшдаг тухай бичсэн байдаг бөгөөд гэхдээ энэ тухай доорх дүгнэлтийг хийсэн байдаг. Үүнд: “Чиний хэлний хэлний үзүүрт байгаа зөгийн бал буюу хорны амтыг яаж амтлахгүй байж болох билээ. Яагаад яг үүнтэй адилаар түшмэл хүн хааны орлогоос жаахан ч гэсэн хазаж болохгүй гэж. Усанд хөвж яваа загасыг ус ууж болохгүй гэж хэлж болохгүйтэй адилаар засаг захиргааны түшмэлийг чи өөртөө мөнгө авлаа гэж хэлж болохгүй” гэжээ. Энэ нь тухайн улс орнуудад хэрэглэгдэж байсан ийм зарчмийг өөрчилж амжилгүй, Их Монгол гүрэн салан тусгаарлаж, олон улс, гүрэн болж хуваагдсантай, нэг талаар холбоотой юм.

Монголын түшмэд ёсны хөгжил нь дорно дахины (ялангуяа Хятад, Дундад Азийн) уламжлалд тулгуурлан Их Монгол гүрэн буюу тодруулбал, Өгөдэй хааны үеэс нилээд системтэйгээр бүрэлдэн тогтсон юм. Хар хүрэм хотод Мөнх хааны үед очсон Францын вангийн элч Г.Рубрук: “...” Эдгээр хорооны гадна ордны түшмэдийн олон том ордон байрлана”¹ гэж бичсэн байдаг нь төрийн түшмэлүүдийн ажлын байр буюу эдүгээгийн яамдуудыг хэлсэн бололтой. Тухайн үед Европт яамны тухай ойлголт огт байгаагүй учраас түшмэдийн ордууд гэж нэрлэсэн бололтой. Ази, Европыг дамнасан том эзэнт гүрнийг удирдахын тулд Өгөдэй хаанд төр захиргааны гүйцэтгэх аппарат

¹ Г.Рубрук, Дорно этгээдэд зорчсон минь, УБ., 1988, х 193.

шаардлагатай болсон юм. Нөгөө талаар хааны ордонтой зэрэгцсэн том хувийн ордонтой түшмэл гэж хаана байх вэ? Энэ нь Ази Европыг дамнасан их гүрнийг оршин тогтноулж, удирдахын тулд тодорхой хэмжээнд төрөлжүүлсэн, иерархи буюу шатлан захирах патримониаль бюрократыг хөгжүүлэхээс өөр аргагүй байдалд хүргэсэн байна.

Өгөдэй хааны үед Хар хүрэмд Их Монголын төрийн байгуулал тодорхой хэмжээнд төрөлжих шинжтэй болсон бөгөөд “Алтан улсын жишгээр ‘Чжуншушэн’ буюу Дотоод бичгийн яам гэгч төв гүйцэтгэгч байгууллагыг зохион байгуулж, хот суурин газар монгол даргач нарыг суулгажээ”¹. Түшмэлүүдийн засгийн газрын бүтцийг анхандаа зохих хэмжээгээр боловсорсон дээд ангийнхны үр хүүхдүүд буюу “Хишигтнүүдэд” тулгуурлан бүрдүүлсэн байна. Их гүрний өсөлт хөгжилтөнд энэ нь цаашдаа хангалтгүй болж ирсэн учраас, эртний Хятадын төрт улсууд төр захиргааны албадаа эрдэмтэй, авъяаслаг хүмүүсээр нөхөн сэлбэхэд хэрэглэдэг байсан бэлэн энэ журмыг “Дотоод бичгийн яамны эрхэлсэн сайд Чу мэргэний (Елюй Чуцай) хүсэлтээр, Өгөдэй хаан “бичгийн мэргэд шалгаруулж төрийн албанд авах тухай” зарлигийг 1235 онд гаргажээ. Төрийн албыг эрдэмтэй авъяаслаг хүмүүсээр нөхөн сэлбэж, тэлэх шаардлагын үүднээс сонгодог зохиол, алба гувчуур, улс орны цаг үеийн асуудал, монгол хэл гэсэн дөрвөн сэдвээр бичгийн шалгалтыг 1237 онд авч, бичгийн эрдэм мэдэх янз бүрийн үндэстэний 4030 хүн шалгаруулалтанд оролцжээ”².

Чингис хаан: “Хүн хэдий сэцэн төрөвч сургуулиас ангид бол мэргэн үл больюу, мэргэн сэцэн түшмэл улсын эрдэнэ, алив үйлчингээс аялгуу билэгт хүн хэрэгтэй, түм түмэн хүнээс нэгэн төр ёс мэдэх хүн дээр буй” гэж айлдсан нь тэр үеийн төрийн түшмэд бэлтгэх бодлогын гол чиг шугамыг урьдчилан илэрхийлжээ. Алтан товч хэмээх монгол сурвалжаас үзвэл хэл бичиг, уран зохиол, улс төр, хууль цааз, цэргийн хэргийн ухаанд монголын дээдэс язгууртны хүүхдүүд шавь сургалтаар суралцаж байжээ. Мөн алтан ургийн хөвгүүдийг сургахад шавь сургалтыг онцгойлж байсан бөгөөд харь орны багш нараар ч хичээл заалгадаг байжээ. Тухайлбал, Г.Рубрук Мөнх хаантай уулзах үед, хаан үдээс өмнө дөрвөн улсын элчийг хаан хүлээж аваад тэдэнтэй өөрсдийнх нь хэлээр чөлөөтэй ярилцаж байсныг дурьдсан байдаг нь шавь сургалтын чанарыг илтгэх төдийгүй, Их Монголын төр мэдлэг боловсролд суурилж

¹ Д.Наран, Монголын төр ёсны боловсролын түүх, УБ., 2001, х 27.

² Д.Наран, Монголын төр ёсны боловсролын түүх, УБ., 2001, х 99.

байсныг харуулж байна. Мөн олон баримтуудад Элжигдэй, Чингай чинсан, Аригун, Хутуг нарын олон түшмэлүүдийг хэд хэдэн хэл мэддэг, өндөр боловсролтой хүмүүс байсныг дурьддаг.

Их Монгол гүрний олон үндэстэн, угсаатнаас бүрдсэн, олон төрлийн шашинтай асар их газар нутаг, хүн ам бүхий төрийг тогтоон барьж удирдах асуудал, мөн тэдгээрийн нийгмийн дээд анги давхрагын ашиг сонирхол, түүний байр суурийг хамгаалж чадах бичгийн болоод төрийн хэргийн мэдлэг боловсролтой хүмүүсийг сургаж бэлтгэх нь тухайн цаг үеийн шаардлага болсон юм. Төрийн залгамж халаагаа бэлтгэх болон төрийг удирдлагаар хангах түшмэлүүдийг бэлтгэх зорилгоор Өгөдэй хаан 1235 онд Их Монгол Улсын Хөвгүүдийн Сургуулийг анх байгуулжээ. Энэ сургууль нь харь орнуудыг захирахад шаардлагатай бичээч түшмэд буюу дэлхийн улс орнууд, хууль дүрэм, төрийн татварын бодлого, харь орнуудын шашин, зан суртахууны онцлог тэдгээрийн хэл бичгийг судалсан, төрийн монгол түшмэлүүдийг бэлтгэн гаргадаг байсан байна.

Судлаач Д.Наран "Монголын төр ёсны боловсролын түүх" номондоо 1235 онд Өгөдэй хаан "Улсын Хөвгүүдийн Сургууль" байгуулах зарлигийг анх гаргасан тухай бичсэн төдийгүй, түшмэлийг шалгаруулж авах журмын тухай монгол хүнээс хоёр, өнгөт нүдтэнээс гурав, харин хятад хүнээс дөрвөн шалгалт авах тухай дурьдсан байдаг бөгөөд ялангуяа дөрөв дэх шалгалтыг Күнзийн суртлаар авдаг байсан гэжээ. Гэвч энэ шалгалтуудын нэг дэх нь дэлхийн байдал, хоёр дахь нь татвар болон хууль эрх зүйн мэдлэг, гурав дахь шалгалт нь монгол хэл бичгээр авдаг байв. Харин дөрөв дэх шалгалт нь Күнзийн баримт бичгийн сургааль буюу хятадын бюрократ ёсны мэдлэгээр авдаг байсан бололтой. Учир нь тэдний бюрократ уламжлалын мэдлэг, туршлага тодорхой хэмжээнд хэрэгцээтэй байсантай холбоотой юм. Бюрократыг судалдаг хойд хөршийн дийлэнх судлаачид Оросын бюрократ нь өрнөдийнхөөс өвөрмөц, өөрийн гэсэн өнгө аяс суурьтай, энэ нь Монголын дарангуйллаар дамжин хятадаас орж ирсэн бололтой гэж үзсэн байдаг. Тухайлбал, оросын судлаач Обломов "Орост XIII зуунаас Византи, Татарын загварууд хослон голчилж байсан. Гэвч сүүлчийн хятадын бүдүүвчилсэн загвар нь ихэвчлэн татвар хураах хэлбэрээр

хэрэгжиж байсан юм. Ийм гайхалтай хэлбэрээр Алтан Ордны үеийг дамжин хятадын бюрократ загвар Орос улсад орж ирсэн”¹ гэжээ.

Монголын тулгар төр улс байгуулагдаж байсан эхний цаг үед төрийн түшмэдүүд, монгол туургатны нэгдсэн төр ёсыг бэхжүүлэхэд үйлчилж байсан бол дараагийн үе шатандаа харь оронд тогтоосон Их Монгол гүрний ноёрхлыг хамгаалахад үйлчилж байв. Харь үндэстнүүдийг удирдахад тэдний дээд ангийнхныг болон түшмэдүүдийг их хэмжээгээр ашиглаж байсан бөгөөд тэдгээр орнуудын хүн амын амьдралын хэм хэмжээ, ёс заншил, шашин шүтлэгийг өөрчлөлгүйгээр “Их Засаг” хуулиар баталгаажуулж өгсөн явдал нь Их Монгол улсын оршин тогтноход нааштай нөлөө үзүүлсэн юм. Их Монгол улсын төрийн засаглалаа хэрэгжүүлэх төрийн аппарат (түшмэл ёс) нь боловсрол мэдлэг, ур чадварт тулгуурлан, нас, үндэс угсаа үл харгалзсан ажилтнуудтай (түшмэлүүд) болж эхэлсэн явдал нь төрийн удирдлагын рационал шинжийн эхлэлийг тавьсан юм.

Түшмэдийн зэрэг дэв, эрх мэдлийн ялгааг тогтоож (эрхэлсэн түшмэл, ялгагч түшмэл, сургагч түшмэл гэх мэт) өгсөнөөр төрийн яамдад, харин засаг захиргааны нэгжид аравтын системээс гадна хот, балгадыг захирах даргач, баскач гэх мэт албан тушаалуудыг бий болгосноор цэрэг армид байсан эрх мэдлийн иерархи буюу шатлан захирах ёсыг төрд төлөвшүүлжээ. Мөн тэдгээр түшмэлүүдэд “Сайн бичээч”, “Тулгат бичээч”, “Сайн багш бичээч” гэх мэт цол олгож байсан нь мэдлэг боловсрол, ажлын үр дүнгээр ахин дэвших карьерийг бий болгосон юм.

Өгөдэй хаан төрийн удирдлагын зарлиг шийдвэрийг улс орны газар бүрд шуурхай хүргэх зорилгоор өртөөний алба байгуулсан нь дэлхий дахинд шинэ зүйл болсон бөгөөд энэ нь худалдаа наймаа, харилцаа холбоо зэрэг бусад олон салбарт нааштай үр нөлөө үзүүлсэн юм. Энэхүү өртөөг байгуулахад тэр үедээ хаана ч хөрвөх чадвартай, ханш өндөртэй валют болох 300 алтан “балыш”-ийг Өгөдэй хаан хувиасаа хандивлаж байв. Өртөөгөөр дамжих төрийн онцгой албан бичгийг хүргэх буухиа элч нарыг нас, бие бялдар, нийгмийн гарал угсаа, ноёлогч ангийн давхаргад хамаарах зэргийг харгалзан авдаг бөгөөд тодорхой бага хугацаагаар ажиллуулж, ихээхэн хангамж эдлүүлдэг байжээ. Учир нь: буухиа элч нь хувцасны гадуур чийгтэй, урт, өргөн бүс, даавуугаар биеэ хөвчлөн ороож, хоногт 400 километрийн хурдтайгаар хэдэн мянган бээр буухиалан давхидаг байсан бөгөөд энэ нь төрийн нууцад хамаарах

¹ Обломов, Государственный служба, М., 1994.

чухал ажил байсан учраас, харц язгуурт хүнээр хийлгэдэггүй, мөн түүний зэрэглэлд тохируулан тусгай “гэрэгэ” хэмээх пайзыг олгодог байв.

Бюрократ удирдлага нь албан бичгээс эхэлдэг бөгөөд монголчууд төрийн ёсны бичгийн хөгжлийн эртний соёлтой, бюрократ элемент тодорхой хөгжиж байсан орны нэг мөн гэдгийг Их Монгол гүрний албан бичгийн соёл илтгэдэг. Их Монгол улсын уламжлалт албан бичиг нь бүтцийн хувьд толгой, үндсэн хэсэг, батламж гэсэн гурван хэсгээс бүрддэг байсан нь өнөөгийн албан бичгийн эх үүсвэр бөгөөд бараг тэр чигээр нь өнөө үед ашиглагджээ. Их Монгол улсын албан бичигний дээд талын сул зайны дунд хэсэгт “Өргөх бичиг”, “Айлтгах бичиг”, “Өргөн барих бичиг” гэсэн байвал доороос буюу доод тушаалтнаас дээд газар болон дээд тушаалтанд явуулсан бичиг болох нь мэдэгддэг. Харин “Тушаах бичиг”, “Мэдтүгэй хэмээх бичиг”, “Зарлиг” гэх мэтчилэн бичсэн байвал дээрээс доошоо явуулсан бичиг байдаг. Мөн Их Монгол улсын албан бичгийн ёсонд албан бичгийн төгсгөлд “Үүний тул мэдтүгэй”, “Үүний тул өргөв” гэх мэт бичдэг нь уул бичгийг явуулсан зорилгыг давтан сануулж, алгуурлаж болохгүй, гүйцэтгэх хэрэгтэй, одоохон хариу ирүүл гэсэн санааг дипломат ёс намбатайгаар сануулсан байдаг. Харин бичгийн эхэнд хаанахын ямар албан тушаалтай хэнээс хаана, ямар удирдлагын албаны хэнд, юуны учир явуулсан бичиг болохыг уул албан бичгийн эхэнд шууд бичдэг байсан нь албан бичгийн нэр сүрийг өргөдөг эрхэм ёс байжээ. Мөн ялгах түшмэлүүд албан бичигт тамга дарсан он сар өдрийг нарийн хөтөлдөг байсан байна¹. Ил хаан Өлзийтийн Францын ванд илгээсэн захидлын эхэнд Өлзийт султан үг мину гэсэн толгой байгаа нь тухайн албан бичгийг Өлзийт хааны захидал гэдгийг тодотгож өгөөд зогсохгүй гарчгийн дэргэд төрийн тамгаа дарж баталгаажуулсан байна. Захидлын төгсгөлд “Мөнх тэнгэрийн ташуурын үг мину” хэмээсэн нь захидлын агуулгыг давтан сануулж, хүчжүүлсэн байна. Энэ нь дээрх албан бичгийн загварын ёс журам, хэвшлийг агуулж байгаа нь Их Монгол улсын төр ёсны болон түшмэл ёсны хөгжил өндөр түвшинд байсныг баталж байгаа билээ.

Их Монголын патримониаль бюрократ төрд алдарт олон сайд бичээч түшмэд байсныг түүхийн олон эх сурвалжуудад, тэдэнд холбогдолтой үйл явдлуудаар дурдсан байдаг. Тухайлбал “сайн бичээч” цолт Иланэр, Жүндүгийн их даргач Мэнсигэ (Мяньсыгэ), бичээч-хэлмэрч Хутуг, Хэжү, Мисүмэн, их ноён Болд чинсан, заргач Ялвач, ДБЯ-ны харьяа 6 яамдын асуудлыг хариуцсан “өнгөт нүдтэн” түшмэл

¹ Ж.Нямбуу. “Монгол зан заншлын Их тайлбар толь” УБ., 1992, х

Сайдэнчи (Сайд Азаль Шамс ад-дин)¹, заргач Тархун, Ойрадын мянганы ноён Тачирын хүү бичээч Аригун (хожим Иран орныг захирах баскач болтолоо дэвшиж, түүхэнд Эмир Аргун хэмээн алдаршсан) гэх мэт. Их Монголын төрд зүтгэж байсан эдгээр болон бусад олон түшмэдийг үгүйсгэх аргагүй билээ. Өгөдэй хааны үед Монгол угсааны Кидан гаралт Елюй Чуцай буюу Чу мэргэн Дотоод Бичгийн Яамны (ДБЯ) эрхэлсэн чинсан (сайд), Зүрчид гаралт Наньхэжуншан ДБЯ-ны зүүн этгээдийг хариуцсан тэргүүн чинсан, Хэрээд угсааны Чингай ДБЯ-ны баруун этгээдийг хариуцсан тэргүүн чинсан буюу сайд байжээ. Өмнөд Сүн улсын элч Сюй Тин, Пэн Дая нарын "Хар татарын хэргийн товч" хэмээх тэмдэглэлд "... дөрвөн сайд байхаас Илжигдэй, Ила Чуцай (Елюй Чуцай), Наньхэжуншань нар хятад газрын хэргийг хамаарна. Төрийн асуудлаа Ила Чуцай, Чингай хариуцдаг. Тэд бие биенээ "бичээч" гэж дуудна, овог хэрэглэнэ гэж үгүй бичиг хэрэг хариуцдаг хүнээ "бичээч", ард иргэдийг хариуцдаг хүнээ "даргачи" хэмээн дууддаг" гэжээ². Судлаач Д.Наран Их Монгол болон Юань гүрний боловсролын тогтолцоогоор түүний бюрократ тогтолцооны үндсийг олон эх сурвалжуудад тулгуурлан илрүүлсэн юм.

Их Монголын патримониаль бюрократ нь Юань гүрний үед Хятадад төвлөн шилжсэнээр, гүрний хязгаар нутаг болон хувирсан Монголд үргэлжлэн эрчимтэй хөгжиж чадаагүй нь хэд хэдэн үндсэн шалтгаантай байсан юм. Үүнд: **Нэгдүгээрт**. Хубилай хаан Монголын нийслэлийг Хархориноос Бээжин рүү шилжүүлсэн нь Юань гүрний улс төр, эдийн засаг, оюун санааны болон нийгмийн бүхий л нөөцийг хятад руу чиглүүлэх болсон юм. Учир нь аж үйлдвэржилтийн эрчимтэй хөгжилт, хотжилтын үе буюу ХХ зуун хүртэл үндсэндээ дэлхий ертөнцийн улс орнууд нийслэлдээ төвлөрөн хөгждөг нь байсныг түүх мартахгүй. Өөрөөр хэлбэл, нийслэл нь тухайн улс үндэстний нүүр царай, хөгжлийн тэргүүлэгч хүч болдог, төдийгүй төрийн хууль ёс, засаг захиргааны үндсэн төв нь болдог байв. Их Юань гүрний үед Монгол орон гүрний хязгаар нутаг болж, тэнд уламжлалт язгууртнуудын (патриархаль) засаглал сэргэн, байр сууриа бэхжүүлсэн юм. **Хоёрдугаарт**. Зуун жил Юань гүрний хязгаар "Давааны арын" нутаг болсон Монгол оронд эзэн гүрний давуу эрхийн үр дүнд "Их Засаг" хуулийг их гүрний дотоодод бие даан баримталж байсан явдал нь уламжлалт орон нутгийн патриархаль системийг бат бөх тогтоох үндэс болсон юм. Хубилай хааны

¹ К.Д.Оссон, История Монголов, т.1.перевод Н.Козьмина, Иркутск., 1937.

² В.В.Бартольд, История изучения Востока в Европе и в России. С.Петербург. 1911.

соёрхон баталсан “Ярьж эмхэтгэсэн хуулийн бичиг” хэмээх 1262 онд гаргасан анхны хууль нь, түүний “Их Засаг” хуулийг зөрчин ёс бусаар хаан ширээг булааж авсанд дургүйцсэн монголчуудад идээшсэнгүй. Улмаар их гүрний олон талт харьцаагаар баяжуулсан, дорнын өвөрмөц бюрократ тогтолцоог үндсэнд нь бий болгосон “Их Юаны хуулийн нэвтэрхий бичиг”, “Их Юаны хууль цаазын бичиг”, “Ертөнцийг засах магад хууль” зэрэг томоохон хуулиуд нь монгол нутагт гэхээсээ хятад газарт, түүний ноёрхлыг хадгалахад илүүтэй үйлчилж байсан юм. Эдгээр хуулиудын эрх зүйн орчин нүүдэлчдэд нийцэхгүй байсан нь, гал голомтоо сахисан монголчуудад уламжлалт “Их Засаг” хуулиа баримтлахаас өөр аргагүй байдалд нэг талаар хүргэж байв.

Гуравдугаарт. Нэгдсэн тогтвортой төр улс оршин тогтнож чадаагүй бөгөөд байнгын бутрал тэмцэл үүнд онцгой нөлөөлсөн. Учир нь хятадаас зугатаж ирсэн дээд язгууртнууд, тэдгээрийн түшмэлүүд болон орон нутгийн уламжлалт язгууртнууд хоорондын зөрчил хурцадсан. “Хойноос ирээд хот минийх, хотонд ороод хонь минийх” гэдэг үг хэллэг ч эндээс гарсан аж. Мөн Хубилай, Аригбух нарын удмынханы өс хонзон ч сэргэж эхэлсэн байна. Тогоонтөмөр болон түүний дараагийн хаадууд удирдлагын зөрчлийг бууруулахын тулд, нийтийн дайсан Мин улстай дайтаж, Их Юань улсыг дахин сэргээхийг уриалж, улсаа “Ар Юань” хэмээн нэрлэж байв. Гэвч дайн зохион байгуулалтгүй, удирдлагын нэгдэл сул, идэвхгүй шинжтэй сунжирсан юм. Учир нь орон нутгийн уламжлалт язгууртнууд өөрсдийн цэрэг, эдийн засгийн хүч нөөцөө хадгалж үлдэхийг урьтал болгосон юм. Дайн тэдний тэргүүн зорилго бус, харин Монгол нутаг дахь ноёрхлоо хадгалж үлдэх нь чухал байсан бөгөөд улмаар ноёрхлоо тогтоох нь хоёр хүчний хэн хэнийх нь үндсэн зорилго байсан юм. Энэ тэмцэл нь Ойрдуудыг биеэ даасан гуравдагч хүч болох боломжийг олгосон юм. Ингэснээр бие даасан язгууртнуудын Монголын хаан ширээний төлөөх засаглалын уламжлалт мөнхийн тэмцэл XVII зуун хүртэл өрнөжээ.

Дөрөвдүгээрт. Юань гүрнээс уламжилж үлдсэн Монгол угсааны түшмэлүүдийн мэдлэг мэргэжлийг хэрэгжүүлэх орчин нөхцөл байгаагүй буюу байнгын хямралын улмаас устсан. “Давааны арын” мартагдсан нутгийн эдийн засаг нь уламжлалт нүүдлийн мал аж ахуй дээрээ суурилж үлдсэн бөгөөд Их Юань гүрний хөгжил дэвшил түүнд наалдсангүй. Иймээс ч энэ нь хятадаас ирсэн монгол угсааны патримониаль түшмэлүүдийг ажилгүй болгосон төдийгүй, тэдэнд төрийг хутган үймүүлэх шинэ ажил ноогдуулсан юм. Ийнхүү гадагш явуулах идэвхгүй сунжирсан дайн, дотоодын олон зуун жилийн хямрал нь Монголын

газрын хөрсөн дээр XIII-XIV зуунд боссон хорь гаруй хот суурингаас нэгийг ч үлдээсэнгүй. Монгол нутагт угсаа залгамжилсан язгууртнуудын ноёрхол бэхжсэн болон үндэсний үйлдвэрлэл нь зөвхөн нүүдлийн мал аж ахуй дээр тогтож байсан зэрэг нь хөдөлмөрийн хуваарийн ялгааг бууруулснаас гадна, хууль болон эрх зүйн зөрчил нь олон жилийн хямрал тэмцлийн үндсийг тавьсан зэрэг үндсэн дөрвөн шалтгааны улмаас Монголд патримониаль бюрократ оршин тогтох боломжгүй болсон юм. Гэвч энэхүү төр ёсны уламжлал тодорхой хэмжээнд хадгалагдаж үлдсэн нь одоогийн монголчуудын хүлцэнгүй, тэвчээртэй менталитетаар илэрдэг.

XIII-XV зууны үеийн Их Монголын эзэнт гүрний засаглалын нөлөө дэлхий дахинд абсальют (хэмжээгүй эрхт) хаант засаглалыг бэхжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэжээ. Энэ нь хааны эрх мэдлийг патриархаль (уламжлалт) язгууртнуудын болон шашны фундаменталистуудын (тулгуур үзэлтнүүдийн) нөлөөнөөс гарахад патримониаль бюрократ буюу эзэн хаанаас хараат, өв залгамжилсан түшмэлүүдийн тоог олшруулж, шашныхан болон уламжлалт язгууртнуудын үүрэг ролийг бууруулж өгөхөд түлхэц үзүүлсэн юм.

Энэ үед Баруун Европт католик сүм хийдүүд тодорхой хэмжээнд өөрийн бюрократ аппараттай байжээ. Харин европ дахь төр улсууд нь засаглалын хувьд шашны болон уламжлалт язгууртнуудын патриархаль төрийн хэлбэрийг даван туулах шатандаа дөнгөж орж эхэлж байсан юм. Дорнын (Их Монголын) аюулын нөлөөгөөр абсальютизмын хөгжил Европт хүчтэй явагдаж эхэлсэн нь хаант засаглалд хүчтэй нөлөөлдөг патриархализмыг шахаж, патримониализмд шилжих шилжилт аажмаар явагдаж эхэлсэн юм. Өөрөөр хэлбэл эзэн хаанд нөлөөлөх уламжлалт язгууртнуудын шахалтыг бууруулахын тулд, мөнгөн барьцаагаар олон түшмэлүүдэд цол хэргэм олгох, түүнийг нь үе залгамжлуулах, худалдах, хураан авах эрхийг баталгаажуулсан юм. Ингэснээр аажимдаа Европт эзэн хаанд шахалт үзүүлж чадах томоохон язгууртнуудгүй болгож чадсан юм.

М.Вебер "бюрократ нь үнэлэмж баримжааллын хувьд төвийг сахисан шинжлэх ухааны чиглэл мөн¹ гэж түүний рациональ шинжийн нэг талыг тодорхойлсон нь Их Монголын төрийн удирдлагын шинж чанартай тохирч байгаа билээ. Учир нь эзлэгдсэн орны түшмэлүүд Монголын захиргаан дор улс орныг удирдахдаа төвийг сахьсан хэлбэрийг голчлон баримталж байсан олон жишээ түүхэнд үлджээ. М.Вебер

¹ М.Вебер. "Избранные произведения" стр 142

“Бюрократ бол аристократуудын халааг авч гарч ирсэн” гэж үзсэн байдаг бөгөөд энэ нь Их Монголын төрд аристократууд буюу “Хишигтнүүд” бюрократ цөмийг анх бүрдүүлж байснаараа ялгаатай боловч, аажимдаа төрийн удирдлагын хэрэгцээ шаардлагын улмаас яс үндэс, нийгмийн давхрагын ялгаа арилж, зөвхөн мэдлэг боловсролд тулгуурлах болсон нь түүний мөн чанартай нийцэж байгаа билээ. Энэ үеэс монголчуудад уламжлагдаж ирсэн төрийн түшмэл хүний үндсэн шинжүүдийг тоочсон сургаалын мөн чанарыг үзэхэд, патримониаль төдийгүй рационал бюрократын шинж чанарыг ч агуулсан байдаг.

Улс орнуудын эртний түүх соёл нь ард түмний ухамсарт шингэн аман яриа, зүйр цэцэн үг, үлгэр домгоор дамжин уламжлагдан, хадгалагдаж ирдэг билээ. Монголын төр ёсны хөгжлийг илтгэсэн “Төр төмбөгөр, ёс ёмбогор” эсвэл, “Төр төмөр нүүртэй, төрсөн бие хоёр нүүртэй” гэх мэт философийн гүнзгий агуулга бүхий үг хэллэг өнөөг хүрч ирсэн нь эртний бюрократ уламжлалыг илтгэсэн үг хэллэг юм. М.Вебер “Бюрократ байгууллага бий болсон явдал нь хүн төрөлхтөний хөгжлийн чухал үе бөгөөд нийгмийн шинэ шатанд дэвшсэнтэй адил юм” гэж хэлсэн байдаг.

Abstract : The article deals with certain specific polity features of the Great Mongolian State, in that this state shared some elements of federalism, and that the nature of the government organization of the Empire was loosely based on the patrimonial bureaucracy.

Ном зүй

1. Улс төрийн шинжлэх ухаан, МУИС, УБ., 2001
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх, УБ., 1981
3. Монголын нууц товчоо, Ц.Дамдинсүрэнгийн орчуулга, УБ., 1947, 1976, 1990
4. Ч.Жүгдэр, Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр гүн ухаан сэтгэлгээ, УБ., 2002
5. Ц.Дамдинсүрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгт, УБ., 1995
6. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин УБ., 1988
7. Ж.Бор. Монгол хийгээд Евроазийн дипломат шастир. УБ., 2001
8. Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988
9. Г.Рубрук “Дорно этгээдэд зорчсон минь”. 1988
10. Д.Наран, Монголын төр ёсны боловсролын түүх, УБ., 2001

11. А.Юндэндорж. Эртний өрнө дорны мэргэдийн улс төрийн сэтгэлгээний онол. УБ., 2001
12. Ч.Аръяасүрэн.Х.Нямбуу. Монгол ёс заншлын Их тайлбар толь.УБ.,1992.
13. М.Вебер. Улс төр бол мэргэшил мөн, Шинжлэх ухаан бол мэргэшил мөн, УБ., 2000
14. Ж.Болдбаатар Ц.Батбаяр З.Баасанжав, Монгол улсын түүх, УБ., 1999.
15. Д.Чулуунжав, Монголын байлдан дагууллын шалтгаан, нөхцөл, үр дагаварын асуудалд, /Философи эрхийн судлал, боть 20/ УБ., 2006
16. Ц.Батболд, Монголд тулгар төр тогтох үе дэх улс төрийн засаглалын патримониаль маягийн хэв шинжийн онцлог, МУИС, НШУС, Эрдэм шинжилгээний бичиг, № 245 Түүх IV (24), 2005
17. М.Вебер. Избранные произведения. М., 1990
18. К.Д.Оссон, История Монголов, т.1.перевод Н.Козьмина, Иркутск., 1937
19. В.В.Бартольд, История изучения Востока в Европе и в России. С.Петербург. 1911
20. Л.Обломовский. Государственные служба. М., 1997
21. Г.В.Атаманчук. "Теория государственного управления" М., 1994
22. М.В.Масловский. Теория бюрократии Макса Вебера и современная политическая Социология, /Полис/ М., 1997
23. П.П.Гайденко., Ю.Н.Давидов. Проблемы бюрократии у Макс Вебера. //Вопросы философии. М., 1991
24. М.Weber, Wirtschaft und Gesellschaft. Tubingen, 1976
25. D.Bade. Khubilai khan and the beautiful princess of tumapel.UB.,2002